



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 587

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин
зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь заалт, 44 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарими арга хэмжээний тухай” 2019 оны 268 дугаар тогтоолын 4.4, “Мэдээ, тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 28,500,000.00 (хорин найман сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг дахин (3 дахь) зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын дарга М.Мөнхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, бүртгэх;

2.4. Худалдсан автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны 1 дүгээр сарын 08 -ны өдрийн
 587 дугаар тогтоолын хавсралт

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
 НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИН**

Д/д	Автомашинны нэр, зориулалт, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	ТӨБЗГ-ын 2018 оны 540 дүгээр тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Тоёота Ланд куруйзер-80 суудлын автомашин, улсын дугаар 11-01 БӨТ, арлын дугаар HDJ 810031998	1993/2007	276978	28,500,000.00	4,500,000.00	2,000,000.00
Нийт дүн				28,500,000.00	4,500,000.00	2,000,000.00
				(Хорин найман сая таван зуун мянга)	(Дөрвөн сая таван зуун мянга)	(Хоёр сая)